

Д.Баярхүү

Орос: Чечениэс
салахгүй, харин
Донбассыг бол салгана

С.Баясгалан

Орос, өрнөд хоорондын
зөрчилдөөний үеийн Орос,
Японы харилцаа

О.Машбат

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт
өөрчлөлт оруулах нь:
Системийн цэгцийг алдагдуулах аюул

БОДЛОГЫН МЭДЭЭ

POLICY NEWS

AD CURRAM ET COMMUNICO!

2017.04 №4



Бодлогын судалгааны төв
Монгол Улсын Их Сургууль
Олон Улсын Харилцаа,
Нийтийн Удирдлагын Сургууль

РЕДАКЦИЙН ЗУРВАС

01 Үнэн үг

СУРГУУЛИЙН МЭДЭЭ

02 Монгол Улс цөмийн зэвсэггүй бүс болсноо зарлан тунхагласны 25 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал болов

ХӨРШ ОРНУУД

04 Орос: Чечениэс салахгүй, харин Донбассыг бол салгана

06 “Бүс ба зам”: Санаачилгаас зөвшилцөл рүү

ОЛОН УЛСАД

08 Орос, өрнөд хоорондын зөрчилдөөний үеийн Орос, Японы харилцаа буюу Шинзо Абэгийн Москвад хийсэн айлчлал

ОНЦЛОХ СЭДЭВ


10 Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь: Системийн цэгцийг алдагдуулах аюул

Дугаарыг эрхлэн бэлтгэсэн:

Х.Бэхбат
Б.Индра

Эх бэлтгэгч:
Хэвлэсэн газар:

Х.Балдандорж
“Мөнхийн үсэг” ХХК



ҮНЭН ҮГ

АНУ-ын ерөнхийлөгч асан Ж.Ф.Кеннеди нэгэнтаа: “Domestic policy can only defeat us; foreign policy can kill us” гэжээ. Үүнийг манайхан: “Бид дотоод бодлогын алдаанаас болж зөвхөн ялагдал хүлээх бол гадаад бодлогын алдаанаас болж сүйрч мэднэ” хэмээн урт боловч утга санааг нь оновчтой илэрхийлэн орчуулсан байдаг.

ЖФК ийнхүү хэлэхдээ дотоод бодлогын ач холбогдлыг доош нь хийх гээгүй, зөвхөн учирах аюулын түвшнийг нь заах гэсэн бизээ. Нээрээ ч гадаад бодлогын алдааг засаж залруулж болдоггүй, боллоо гэхэд ч ихээхэн хүч чармайлт, цаг хугацаа шаарддаг гэнэ. Эдгээр үгс АНУ шиг их гүрний хувьд үнэн бол манайх шиг бага, буурай, тэр тусмаа геополитикийн ийм онцгой байршилтай улсын хувьд туйлын үнэн гэлтэй.

Тэгвэл бид гадаад бодлогодоо /стратегийн/ алдаа гаргахгүй байх үндэс юунд байна вэ? Бие даасан, бүрэн эрхэт байдлаа шамшигдуулан улмаар үндэсний аюулгүй байдлаа хохироохгүй байх баталгаа нь хаана вэ? Засаг төрийн байгууллагуудад уу, улс төрчдийн гарт уу? Нийт нийгмээс шалтгаалах уу, эсвэл тодорхой нэг иргэнээс үү?

Аль алинд нь л зохих хэмжээгээр байх учиртай биз. Гэхдээ энд бяцхан гүнзгийрүүлэн тодруулах нэг зүйл байх шиг санагдана.

Чухамдаа бидний монголчуудын олон улсын харилцааны мэдлэг, боловсрол зузаарч, гадаад бодлогын сэтгэлгээ хөгжиж, бид бүхний “дархлаа” байнга бэхжин сайжирч байхад л гол учиг нь орших бус уу. Өнгөрснийг үл умартан сургамж сүйлж, маргаашийг тандан шинжих үндсэн дээр өнөөдрийн харилцаагаа зөв удирдан залах чадвар юу юунаас чухал аа. Хэдийгээр “туйлын” үнэн үгүй гэдэг ч үүнийг л “туйлын” гэчихмээр бодогдоод байх ажгуу.

Х.Бэхбат

Ж.Энхсайхан

Цэнхэр сүлд ТББ-ын захирал

МОНГОЛ УЛС ЦӨМИЙН ЗЭВСЭГГҮЙ БҮС БОЛСНОО ЗАРЛАН ТУНХАГЛАСНЫ 25 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛОВ

Монгол Улс цөмийн зэвсэггүй бүс болсноо зарлан тунхагласны 25 жилийн ой энэ жил тохиож байгаа тул МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль Цэнхэр Сүлд ТББ-тай хамтран 5 сарын 2-нд “Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгохоор зарласны 25 жил: үр дүн, цаашид тавих зорилт” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал хийв. Энэхүү хуралд олон улсын харилцаа, аюулгүй байдлын асуудлаар судалгаа хийдэг эрдэмтэн, судлаачид, дипломатууд, доктор, профессор, багш, оюутнууд өргөнөөр оролцов.

УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны дарга Ж.Энхбаяр эрдэм шинжилгээний хуралд оролцогсод илгээлт ирүүлсний дээр Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн мэндчилгээ дэвшүүлж, Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статус (ЦЗАС)-тай холбогдсон 13 илтгэлийг сонсч хэлэлцсэн байна.

Монгол Улс цөмийн зэвсэггүй болох тухай санаачилгыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейд анх дэвшүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат илтгэлдээ асуудлыг санаачлах болсон учир шалтгаан, үндэслэл, түүнийг урагшлуулах зөв “хөшүүргийг” олох, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүн бөгөөд цөмийн зэвсэгтэй таван гүрэн болох АНУ, ОХУ, БНХАУ, Их Британи, Франц (буюу Р5)-ын

болгоомжлолыг давах, Монгол Улсын ЦЗАС-ын үндсийг тавьсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол, тус улсын 2000 онд батлагдсан хуулийн үндсэн заалтууд, Р5-аас Монгол Улсад олгосон улс төрийн баталгааны агуулга, ач холбогдлын талаар тодорхой дурдахын дээр залуу үеийнхэнд хандаж эх орныхоо үндэсний аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт биечлэн оролцож их үйлсийг бүтээхийг уриалав.

УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны дарга Ж.Энхбаяр ирүүлсэн илгээлтдээ тус улсын санаачилгыг дэлхийн улс орнууд өргөнөөр хүлээн зөвшөөрч дэмжих болж, Зүүн хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдлын хамтын тогтолцоог бий болгох олон улсын чармайлтад оруулж буй тодорхой хувь нэмэр гэж үнэлж буйг цохон тэмдэглэж, энэ бүхэн нь энхийг эрхэмлэсэн Монгол Улсын гадаад бодлогын том амжилт, түүний нэр хүндийг олон улсын тавцанд өргөсөн чухал ач холбогдолтой үнэлэлт болсныг тэмдэглэв.

ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн нээлтийн ажиллагаанд оролцон товч үг хэлэхдээ “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсгээс ангид статус”-ын тухай НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолын зарим заалтын хэрэгжилтийг хангах, уриалга, үзэл санааг бодит ажил хэрэг болгох чиглэлд цаашид идэвх санаачилгатай ажиллах шаардлага байгааг тэмдэглэв.

Эрдэм шинжилгээний хуралд Монгол улсын ЦЗАС-

ын холбогдолтой олон сонирхолтой илтгэл тавив. Тухайлбал, доктор, профессор Д.Мягмар Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээ болон Монгол улсын ЦЗАС-ын талаар, доктор, профессор Д.Уламбаяр “гуравдагч хөрш”-ийн бодлого болон ЦЗАС-ын харилцан хамаарал, гадаад харилцааны сайд асан Н.Туяа Монгол Улсын ЦЗАС ба НҮБ-ын хэм хэмжээ, Р.Нямдаваа Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийн үүрэг, ач холбогдол, доктор Ж.Энхсайхан ЦЗАС-ыг урагшлуулахад цаашид тавих зорилт, ОУХНУС-ийн ахлах багш Г.Баасанхүү энэ асуудлын талаарх нийгмийн ойлголт зэрэг сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Монгол Улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 47 дугаар чуулганд оролцож үг хэлэхдээ тус улсыг цөмийн зэвсэггүй бүс болгож буйг албан ёсоор зарлан тунхаглаж, түүнийгээ олон улсын хэмжээнд баталгаажуулах талаар ажиллах болохоо мэдэгдсэн байдаг. Ийнхүү тунхагласан нь урьд өмнө гадаад аюулгүй байдлаа нэг гүрэнд даатгаж ирсэн Монгол Улсын хувьд эвсэлд үл нэгдэх бодлого баримталж, аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар бэхжүүлэх тухай мэдэгдсэн шинэ Монголын бие даасан, язгуур ашиг сонирхлоо дээдэлсэн гадаад бодлогын анхны нэг тодорхой илэрхийлэл байв.

Р5 нэг улс дангаараа цөмийн зэвсэггүй бүс байгуулах тухай Монгол Улсын санаачилга



нь олон улсын харилцаанд урьд өмнө гарч байгаагүй тохиолдол бөгөөд их гүрнүүдийн стратегийн тэнцвэрт байдал буюу тооцоог алдагдуулж болзошгүй хэмээн үзэж болгоомжилсон хандлагатай байдаг. Монгол Улс уг асуудлаар Р5-тай удаа дараа яриа хэлэлцээ хийсний дүнд тэд олон улсын харилцаанд тийм практик тогттол Монгол Улсыг ЦЗАС-тай улс хэмээн хүлээн зөвшөөрч түүнд зохих баталгааг гаргаж өгч болох юм гэж Монголын талтай тохирсон байна. Улс төрийн тэрхүү тохиролцоог үндэслэн 1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсгээс ангид статус” хэмээх тогтоолыг баталсан байна.

Тэрхүү тогтоол нь Монгол Улсын санаачилгыг сайшаан дэмжсэний зэрэгцээ “тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдал, эдийн засгийн аюулгүй байдал, экологийн тэнцвэрт байдал, бие даасан гадаад бодлого”-оо бататган бэхжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авахад нь Монгол Улстай хамтарч ажиллахыг Р5-ыг оролцуулан нийт гишүүн орнуудад, мөн НҮБ-ын холбогдох байгууллагуудад уриалж, тогтоолын хэрэгжилтийг гаргаж илтгэхийг НҮБ-ын ЕНБД-аас хүссэн байна. 2000 оноос хойш Ерөнхий Ассамблей уг асуудлыг хоёр жил тутам ЕНБД-ын илтгэлийн үндэслэн хэлэлцэж тогтоол гаргадаг болсон байна. НҮБ-ын ЕНБД

энэ асуудлаар 9 илтгэл гаргаж, Ерөнхий Асамблей 10 тогтоол батлаад байна.

Монгол Улс ЦЗАС-саа үндэсний хэмжээнд тодорхойлох үүднээс 2000 оны 2 сард “Цөмийн зэвсгээс ангид байх тухай” хууль гаргаж мөрдөж байна. Монгол Улсын статустай холбогдуулж Р5 цөмийн зэвсэгтэй гүрнүүдийнхээ хувьд 2000 оны 10 сард хамтарсан мэдэгдэл гаргаж тус улсын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхгүй, сүр далайлгахгүй гэсэн улс төрийн баталгаа гаргасан байна. Харин Монгол Улс тэрхүү баталгааны агуулгыг бодит байдалд нийцээгүй, мөн хэлбэрийг хангалтгүй гэж үзэж яриа хэлэлцээг үргэлжлүүлж улмаар талууд 2012 онд паралель тунхаглал гаргаж тэр тухайгаа дэлхийд зарлан мэдэгджээ. Монгол Улс ЦЗАС-аа тодорхойлсон тунхаглал гаргасны хариуд Р5 гаргасан хамтарсан тунхаглалдаа тус улсын ЦЗАС-ыг хүлээн зөвшөөрснөө нотлохын дээр тэрхүү статусыг зөрчих аливаа үйлдэлд дөхөм үзүүлэхгүй байхаа амласан. Тэгснээр Р5 Монгол Улсыг цөмийн зэвсгээр хөөцөлдөх ямар нэгэн ажиллагаанд, түүний дотор пуужингийн довтолгооноос хамгаалах системийн буюу түүнийг эсэргүүцсэн системийн эд ангийг Монголд байрлуулахгүй гэсэн амлалт өгсөн гэж ойлгож болно. Цаашид Монгол Улс Р5-ын улс төрийн баталгааг эрхзүйн үндэстэй болгох ажил үлдээд байгааг бага хуралд оролцогсод тэмдэглээд энэ талаар цаашид хийж болох ажлын талаар

- өөрсдийн санаа бодлыг илэрхийлж байв. Тухайлбал,
- Р5-аас Монгол Улсад олгосон баталгааг эрхзүйн үндэстэй болгоход анхаарч энэ талаар тодорхой арга хэмжээ авах;
 - Монголын статусын асуудлаарх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолын цөмийн зэвсгийн бус арга хэмжээний талаарх заалтууд болон ЦЗАС-ыг шинэтүвшинд гаргах тухай УИХ-ын 2015 оны 60 дугаар тогтоолын заалтуудыг хэрэгжүүлэх зэргийг тусгасан төрийн бодлого боловсруулж гаргах;
 - Р5-ын хамтарсан тунхаглалын тус улсын статусыг хүндэтгэж, түүнийг зөрчих аливаа үйлдэлд оролцохгүй гэсэн заалтыг тэдний хэн нь ч тус улсын нутаг дэвсгэрт бусдын аюулгүй байдал буюу бүсийн тэнцвэрт байдлыг алдагдуулахад хүргэх цөмийн зэвсгийн эд ангийг Монголд байрлуулахаар шууд буюу шууд бусаар даралт үзүүлэхгүй гэсэн санааг агуулж байгаа гэж тайлбарлах талаар ажил зохиох;
 - Нэг улс цөмийн зэвсэггүй бүс болох олон улсын харилцааны онолын үндсийг улс орныхоо туршлагад үндэслэн гаргах, туршлагаа сонирхсон улс орнуудтай хуваалцах;
 - Монгол Улсын ЦЗАС-ын асуудлыг Номхон далайн өмнөд хэсгийн ЦЗБ, Зүүн өмнөд Азийн ЦЗБ-ийн асуудлуудын адил АРФ-ийн хүрээнд тогтмол хэлэлцүүлж байх арга хэмжээ авах;
 - Зүүн хойд Азид ЦЗБ байгуулах асуудлыг албан бусаар хэлэлцэхэд идэвхтэй оролцож, асуудлыг Улаанбаатарт байнга хэлэлцэж байх механизм байгуулах боломжийг судалж ажиллахыг тус тус санал болгож байв.



Д.Баярхүү

Олон улсын харилцааны судлаач-проф

ОРОС: ЧЕЧЕНИЭС САЛАХГҮЙ, ХАРИН ДОНБАССЫГ БОЛ САЛГАНА

Орос, Украин хоёр их дайны босгон тулж ирсэн юм болов уу гэмээр сэтгэгдэл сэтгэдэг боддог хүн бүрт суугаад гурван жилийг туулж байна. Хоёр өөр үндэстэн, хоёр өөр шашинтан бол ч яая гэхэв, таарч тохирох албатай биш үзэлцэхэд гайхах зүйлгүй. Харин үүсэл гарал нэгтэй (славян), нэг шашинтай (үнэн алдартан), нэг соёлтой (оросын ертөнц, кириллица) садан төрөл үндэстнүүд өвөр хоорондоо өсөрхөнө, өсөрхөөд алалцана гэдгийг Дорнод Украины үйл явдал гурван жил нүднээ эвэр ургатал харууллаа.

Донбасс – буюу “ДНР”, “ЛНР” гэх Донецк, Луганскийн “Ардын БНУ”-уудын хувь заяа Москвагаас үлэмж хамаарч байгаа нь нууц биш. Харин үүнд Москва тууштай, ил тод, оновчтой байр суурь баримтлахаас булзаж, гэхдээ асуудлын голыг олохоор арга зам эрэлхийлсээр байх шиг. Украины нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг дэмжинэ гэх ОХУ-ын ГХЯ-ны мэдэгдэл эхэндээ дуулддаг байснаа одоо больсон. Тэрхүү бүрэн бүтэн

байдлаа Украин нь хамгаална, “ДНР”, “ЛНР”-ийг дэмжихээ зогсоо гэх Европын Холбооны шаардлага, АНУ-ын байр суурь хэвээрээ байгаа тул Оросын байр суурь бүр ч холбируод явчихна.

Хориод жилийн өмнөх Оросын өөрийнх нь түүх. Орос-Чеченийн нэгдүгээр дайн өрнөж, одоогийн Украины туулж буй зовлонг ОХУ эдэлж, одоогийн “ДНР”, “ЛНР”-ийн салан тусгаарлагчдын хувь заяа тэр үеийн Чеченийн удирдагчдад яг тохиож байсан хэрэг л дээ. Тусгаар тогтнолыг санаархсан Чеченийн эсрэг 1994 оны 12 дугаар сард Оросын байнгын армийн цэрэг илгээж, дайн 21 сар үргэлжилж, хэн ялах нь мэдэгдэхгүй болж, дэлхийн II дайн-Эх орны дайнаас хойш оросын нутаг дэвсгэр дотор болсон хамгийн аймшигт, хэрцгий дайн хэмээн түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Грозный хот газрын хөрснөөс бараг арчигдан, тэр чигтээ балгас болсон. Оросын армийн нэр хүнд навс унажээ. Адаг сүүлд нь 1996 оны 8 сарын 31-нд Орос өөрийн нэг субъект Чеченьтэйгээ энх тайвны хэлэлцээр байгуулж,

цаадуулынхаа тусгаар тогтноно гэсэн эрмэлзлэлийг 5 жилээр хойшлуулж, 1997 оны эх гэхэд Чечениэс Орос цэргээ гаргаж, гэтэл 1999 оны намар даварсан Чеченийг дахин номхотгохоор Оросын цэрэг хоёр дахиа тийшээ очиж, мөн оныхоо сүүлч гэхэд Грозныйг дахин эзлэн авч, энэ нь Чеченийн II дайн хэмээн түүхнээ үлдсэн юм. Үнэндээ бол Оросын орчин үеийн түүхийн хамгийн шившигт хуудсууд.

Тэгвэл Украин яг ийм замаар ороод гурван жилийг туулж явна. Дэлхийн II дайн-Эх орны дайнаас хойш Украины нутаг дэвсгэр дотор хамгийн аймшигт, хэрцгий дайн өрнөөд түр царцлаа. Донецк, Луганск хот газрын хөрснөөс арай арчигдчихаагүй. Дайн дахин сэдрээд харилцан галлаад байвал мөд балгас болно. Орос өөрийн нэг субъект Чеченьтэйгээ энх тайвны хэлэлцээр байгуулсан шиг Украиныг өөрийн хоёр субъекттэйгээ хэлэлцээр байгуул хэмээн Москвагаас улайм цайм шахлаа. Донбассынхныг тусгаар тогтноно гэсэн эрмэлзлээ 5 жилээр хойшлуул гэж Москвагаас арай тулгаагүй байх

шиг. Донбасс нь болохоор Киевт одоогийн биш, Орост хайртай цоо шинэ өөр төр, засаг бий болбол өргө эрхт автоном байгуулах тухай ярина гээд гэдийчихэв.

Адилхан зохиомжоор хоёр ондоо дайн хуучин СССР-ийн орон зайд 20 гаруй жилийн зайтай өрнөсөн түүх ердөө энэ. Тэгэхлээр одоо ямар шийдэл байна вэ?

Өрнийнхөн, олон улсын институциуд, НҮБ, Европын парламент нь “Новороссия” гэх шинэ холбооны улсыг хэрхэвч хүлээн зөвшөөрөхгүй гэж байна. Донецк ба Луганскийн Ардын БНУ-уудыг Украины бүрэлдэхүүнд федералчилж болохыг хэтдээ зөвшөөрч магад. Гэтэл Киев дэх одоогийн төр, засаг нь унитар улс л байна гэж үздэг. Украины Холбооны Улс гэдгийг гэмт хэрэг хэмээн үзнэ. Гэтэл нөгөөдүүл нь Киевын хяналтад байхгүй ээ, хэзээ дуртай цагтаа референдумаар гарч орж, салж нийлж байх субъект болно гэдэг.

Донецк мужид 2014 оны 5 сарын 11-нд явуулсан референдумаар хүн амын 74.87 хувь оролцож, тусгаар тогтноно гэдэг дээр 89.7 хувь нь санал өгсөн. Луганск мужид 81 хувь нь оролцож, 96.2 хувь нь өрх тусгаарлая гэхисэн. Кремльд референдумыг үр дүнг хүндэтгэнэ гээд амлчихсан. Энэ амлалт нь хэдэн сая хүнд итгэл горьдлого, эх оронч үзэл төрүүлчихсэн. Яг тэр хэвээрээ гурван жилийг үдчихэж.

Дэлхий дээрхи туршлагаас суралцахыг Киевт албан бусаар Кремлиэс санал болгосон хувилбар мэр сэр дуулдсан. Дэлхий дээр олон оронд

автономит ба автономит бус нутаг дэвсгэрийн нэгж, анклав (эх нутгаасаа тасарсан цүлхэн арал газар буюу Калининград муж лугаа адил), эксклав (бүрэн эрх эдэлдэггүй бүс нутаг) бишгүй байдаг ажээ. Үндэстэн ба шашинтнаараа ингэж салж, хагас бие дааж болоод ирсэн түүх буй. XIX зуун хүртэл өрнийнхөн ийм бүтэцтэй явсан нь буй. Явж явж энэ туршлага л Украинд ирж наалдах ёстой юм байх.

Хөрш орноосоо удирдуулдаг Бельги дэх холланд 7 район бий. Гэтэл өмнөд Холландад бельгийн хоёр муж бий. Өмнөд Швейцарьт италийн кантон байна. Өмнөд Францад испанийн Льивиа гэх эксклав байна. Умард Швейцарь дахь герман эксклав (Бюзинген) гэхчлэн. Азид Энэтхэг том жишээ байна. Бангладеш дэх энэтхэгийн хэд хэдэн анклав/эксклав, Зүүн хойд ба Дорнод Энэтхэг дэх бангладеш анклав гэх мэт. Умард Мароккод испанийн Сеут, Мелилья, Мозамбикийн эргийн ойролцоо францын арлууд/эксклав, Зүүн хойд Канад дахь францын анклав, Гибралтар дахь британийн эксклав, манайд ойр, бидний мэдэх Узбекистан дахь Киргизийн районууд, Киргиз дэх Узбекистаны районууд гээд бичвэл олныг жагсааж болж байна.

Энэ юун район, анклав, эксклав вэ гэвэл уугуул эзэн улс нь түүнийг хэнд ч өгөхгүй манайх гээд хав барьчихсан, хөрш орнууддаа хэзээ ч зөвшөөрдөггүй, гэхдээ нөгөө цаад үндэс угсаа нэгт улстайгаа тэдгээр районууд харилцаа холбоотой байж болоод ирсэн, ихэнхи нь де-юре, эсвэл де-факто автономит статустай (жишээ нь Гибралтар). Өөр нэг

туршлага байна. Кондоминиум буюу угсаатан, шашинтны гарлаар нь нэгэн зэрэг хэд хэдэн улс захирч болдог туршлага. Дорнод Кариб дахь Сан-Мартен арлыг Нидерланд, Франц хоёр нэгэн зэрэг захирдаг. Номхон далайд Британи, Францын хамтын захиргаан дор 1906-1980 онд байсан Шинэ Гебрид арал, эдүгээгийн Вануату улс гээд жишээ туршлага буй юм.

ОХУ-ын бодлогыг ажаад байвал байлдуулах бус, тэгшхэн хуваах бус, харин хоёр удирдлагатай тийм статусыг сонирхоод байх магадлалтай. Нагорно-Карабахыг Армен, Азербайжаны хооронд “хоёр хэмжүүр”-тэй нэг улсын туршлагаар шийдвэрлэхийг Москвагаас санал болгож тун магадгүй. Тэгэхлээр Украины хувьд Орос эцсийн бүлэгт яг ийм саналыг Новороссия гэдэг дээрээ тулгаж болох талтай. Украины хувьд эцэс төгсгөлгүй байлдах замыг сонгохгүй нь лавтай. Гэхдээ бууж өгөхгүй. Харин нөгөөдүүл нь улам хүчирхэгжинэ. Цус урсах тусам улам үзэн ядна, улам салж холдоно.

Нагорно-Карабахыг Армен-Азербайжаны хооронд, Данбассыг Украин-Оросын хооронд Гибралтар дахь британийн эксклавын жишгээр тохинуулахыг Москвагаас шийдлээ гэж бодъё. Гэтэл ОХУ-ын доторхи лалын анклав-субъектуудыг яах болж байна вэ гэсэн асуулт зүй ёсоор гараад ирнэ. Хэтдээ ОХУ-ын тогтвортой байдлыг бусних лалын анклавуудын тухай Орос өөрөө таг чиг?

**Б.Индра**

ШУА-ийн Олон улсын харилцааны
хүрээлэнгийн ЭША, доктор (Ph.D)

“БҮС БА ЗАМ”: САНААЧИЛГААС ЗӨВШИЛЦӨЛ РҮҮ

Форумын тухай

Хятад улс дөрвөн жилийн өмнө дэлхийн 60 гаруй улсыг хамарсан “Бүс ба Зам” санаачилга дэвшүүлж байсан бол өдгөө уг санаачилгыг улс орнууд хоорондын зөвшилцөл болгож, нэгдмэл ойлголтод хүрэх зорилгоор 2017 оны 5 дугаар сарын 14-өөс 15-ны өдөр “Бүс ба Зам” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний форумыг Бээжинд анх удаа зохион байгуулжээ. 29 орны төр ба засгийн газрын тэргүүн, нийт 130 улс, 70 гаруй олон улсын байгууллагын 1500 гаруй төлөөлөгч оролцсон уг форум Хятадын энэ жилийн хамгийн том дипломат арга хэмжээ болсон бөгөөд ирэх жил мөн хоёрдахь удаагийн форумыг хийж уулзалт яриа хэлэлцээний механизм болгон хэвшүүлэх бололтой.

Форумын хэлбэр нь дээд хэмжээний дугуй ширээний ярилцлага болохын зэрэгцээ бодлогын уялдаа, дэд бүтэц, худалдаа, санхүү, иргэд хоорондын харилцаа, судалгааны байгууллагууд гэсэн зургаан

салбар хуралдаан хийж, 8 дэд сэдвийг авч хэлэлцсэн нь дэд бүтэц, үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт, худалдаа эдийн засаг, эрчим хүч, санхүү, хүмүүнлэгийн солилцоо, байгаль орчин, далай дахь хамтын ажиллагаа тус тус болно.

Форумын төгсгөлд Хамтарсан тунхаглал гаргаж, хоёр ба олон талт хамтын ажиллагааны 76 баримт бичиг үйлджээ. Үүнээс Монгол Улстай ““Бүс ба Зам”-ын хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын санамж бичиг” болон төмөр зам, худалдаа эдийн засаг, хөрөнгө оруулалт, мэргэжлийн хяналт хорио цээр, зээл олгох, чөлөөт худалдааны хэлэлцээрийн боломжийг хамтран судлах гэх мэт чиглэл тус бүрээр гэрээ, санамж бичиг байгуулсан байна. (Дэлгэрэнгүйг арын хавтасны Тоон мэдээ булангаас үзнэ үү.)

Хятад улс “Бүс ба Зам”-ын анхны форумыг ийнхүү амжилттай зохион байгуулсан хэдий боловч зарим улс орон өндөр түвшний төлөөлөгчөө оролцуулаагүй нь хятадын хүсэж буй зөвшилцөл, нэгдмэл ойлголтод хүрэхэд хугацаа

шаардагдана гэдгийг илтгэнэ. Тухайлбал, Их 7-гийн орнуудаас Италиас бусад 6 улс, БРИКС-ээс ӨАБНУ, Бразил, Энэтхэг улс, АСЕАН-аас Сингапур, Тайланд, Бруней улс, мөн Австрали, Өмнөд Солонгос, тэр бүү хэл холбоотон Умард Солонгос ч өндөр түвшний төлөөлөгчөө илгээсэнгүй. Энэтхэг улсын тухайд “Бүс ба Зам”-ыг бүүр эсэргүүцэж, ГХЯ-ны төлөөлөгч нь “Энэтхэг, Пакистаны хооронд үүссэн маргаантай асуудал болох Гилгит-Балтистаны нутаг дээгүүр дайран өнгөрөх Хятад-Пакистаны эдийн засгийн коридорыг байгуулах явдлыг Энэтхэг улс зөвшөөрч чадахгүй” гэж ширүүн мэдэгдсэн бөгөөд “Бүс ба Зам” форумд эрдэмтний төлөөллөө л илгээсэн байна.

Хэдийгээр энэ мэт сорилтууд тулгарч байгаа ч “Бүс ба Зам” санаачилга хийгээд энэ удаагийн дээд хэмжээний форум бол Хятад улс өөрөө сэдэж, өөрөө гардаж, эх орондоо зохион байгуулж байгаа анхны глобал хурал, тиймдээ ч дипломат томоохон амжилт боллоо гэж шинжээчид дүгнэжээ.

“Бүс ба Зам”-ын талаарх байр сууриуд

“Бүс ба Зам” санаачилгын бүтээн байгуулалтад нийтдээ 900 тэрбум ам.долларыг зарцуулах төлөвлөгөөтэй байгаа нь нэг улс дангаараа хилийн чанадад ийм их хэмжээний хөрөнгө оруулах анхны тохиолдол болно. “Бүс ба Зам”-ыг сайн, саар аль аль талаас нь тайлбарласан байдаг,

уг санаачилга эдийн засгийг өдөөж сэргээнэ гэж байхад дийлэнх төсөл төлөвлөгөө нь геополитикийн өнгө аястай гэж үзэх нь бий, хятадын ААН-ийн өрсөлдөх чадварыг сайжруулна гэж байхад өрийн дарамтыг улам нэмэгдүүлэх эрсдэлтэй гэж үзэх нь ч байна, хятадын нөлөөг дэлхийд тэлнэ гэж байхад оруулж буй хөрөнгөө буцааж олох баталгаа байхгүй

гэх нь бий, дэд бүтэцийн сул зайг нөхөж өгнө гэж байхад Хятад, Пакистаны коридор тогтворгүй бүсээр дайрна гэх жишээтэй, мөн Ойрх Дорнодод хэрэгжих төслүүд нь Хятадыг тэндэх үймээн самуунд татан оролцуулна гэх мэт олон талын янз бүрийн таамаглал явсаар байна.

Ши Жиньпиний уриалга

Хятадын дарга Ши Жиньпин дээд хэмжээний хурал дээр гол илтгэлийг тавьж олон улсад таван зүйлийг уриалжээ.

Нэгд, “Бүс ба Зам”-ыг энх тайван зам болгох: “Улс орнууд бие биеийнхээ тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, сонгож авсан хөгжлийн зам, нийгмийн тогтолцоог хүндэтгэх хэрэгтэй. Эртний торгоны замын дагуух зарим бүс нутаг сүү хийгээд зөгийн балны газар нутаг байсан. Харин өнөөдөр эдгээр газар дайн байлдаан, хямралд нэрвэгдээд байна. Бид ийм байдлыг цаашид үргэлжлүүлж болохгүй” хэмээгээд бүх улс орныг хамарсан аюулгүй байдлын орчныг бий болгохыг уриаллаа.

Хоёрт, “Бүс ба Зам”-ыг хөгжил цэцэглэлийн зам болгох: “Бүх улс орныг хамарсан эдийн засгийн хөгжлийн замыг тавих хэрэгтэй” гэжээ. Ингэхдээ үйлдвэрлэл, санхүү, хэлхээ холбоо гэсэн гурван чиглэлийг онцлов. “Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн шинэ загваруудыг бий болгож, засгийн газар ба хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааг илүү хөхиүлэн дэмжиж,



төрөлжсөн санхүүгийн тогтолцоо болоод олон шатлалт хөрөнгийн зах зээлийг бий болгох хэрэгтэй” гэсэн бол дэд бүтцээр холбогдох тухайд тэрбээр “газар, далай тэнгис, агаар ба кибер орон зайгаар холбогдох боломжийг хөхиүлэн дэмжихийн зэрэгцээ хурдны зам, төмөр зам ба далайн боомтуудын төслүүдэд анхаарлаа хандуулах”-ыг холбогдох бүх улс оронд уриаллаа.

Гуравт, “Бүс ба Зам”-ыг нээлттэй зам болгох: Нээлттэй байдал бол авгалдай уутнаасаа гарч эрвээхэй болдог лугаа адил хэмээгээд “нээлттэй хамтын ажиллагааны талбар болгох хэрэгтэй” гэв.

Дөрөвт, “Бүс ба Зам”-ыг инновацийн зам болгох: “Инновацийг хөхиүлэн дэмжихнээр 21 дүгээр зууны дижитал торгоны зам байгуулна” хэмээжээ. Энэ нь өндөр технологи, ногоон хөгжлийг багтаасан ойлголт юм.

Тав, “Бүс ба Зам”-ыг иргэншлийн зам болгох: “Иргэшлүүд хоорондоо тусгаарлагдах биш харилцах, мөргөлдөх биш хамтрах, нэгнээ хүндэтгэдэг” болохыг уриалаад олон үе шат бүхий хүмүүнлэгийн хамтын ажиллагааны механизмууд бий болгохыг онцлолоо.



С.Баясгалан

МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн багш, доктор

ОРОС, ӨРНӨД ХООРОНДЫН ЗӨРЧИЛДӨӨНИЙ ҮЕИЙН ОРОС, ЯПОНЫ ХАРИЛЦАА БУЮУ ШИНЗО АБЭГИЙН МОСКВАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛ

Украины хямралаас үүдэн АНУ холбоотон орнуудаа ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээ авахад “шахав”. Японд хамаагүй Украины асуудал хамаатай болж АНУ-ын шахалтаар 2014 оны 3 дугаар сард ОХУ-ын эсрэг хоригт нэгдэв. Япон улс ОХУ-ын дээд албан тушаалтан 23 хүнд визны хориг тавьж, хамтын ажиллагааны гурван хэлэлцээг тодорхойгүй хугацаагаар цуцалсан байдаг. Гэвч ОХУ-ын эсрэг хориг тавьсан Япон Оростой харилцаагаа сэргээхийг өөрсдөө хүсэх болов. Үүний гол илрэл нь хоёр орны төрийн тэргүүний айлчлалд хориг төдийлөн нөлөө үзүүлэхгүй байгаа болоод бусад үйл явдлаас харагдаж байна.

Барууны орнуудын тавьсан хориг Оросыг өөрийн эрхгүй Ази рүү хандахад хүргэсэн. Энэхүү бодлогын хүрээнд ОХУ Азийн зах зээл рүү гарах төдийгүй Алс дорнодын бүс нутгаа хөгжүүлэхийн тулд хил орчмын хамгийн ойр орнууд

болох Хятад, Япон, Солонгосоос хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримтлах болж, Владивосток, Находка зэрэг боомт хотуудыг чөлөөт худалдааны бүс болгон ялангуяа технологийн өндөр хөгжилтэй Японы хөрөнгө оруулалтыг татахыг эрмэлзэх болов. Гэтэл Орос, Японы хооронд газар нутгийн маргаанаас үүдэлтэйгээр 1945 оноос хойш энхийн гэрээ байгуулагдаагүй хэвээрээ байгаа ба Япон Орост хөрөнгө оруулах, эдийн засгийн аливаа харилцаанаас татгалзсан бодлого барьж ирсэн юм. Орос харин өмнөд Курилын арлууд нь ОХУ-ын нутаг дэвсгэр бөгөөд энэ асуудлаар яриа байхгүй, харин эдийн засаг, хөрөнгө оруулалтын салбарт хамтран ажиллахад бэлэн байна гэдгээ илэрхийлж байгаа.

2015 онд ОХУ-ын Ерөнхий сайд Д.Медведев маргаантай Курилын арлууд дээр бүтээн байгуулалт хийнэ гэж мэдэгдсэний дараа Японы тал эсэргүүцэл илэрхийлж байв.

Гэвч 2012-2014 оны хооронд В.В.Путин, Шинзо Абэ нар 10 удаа уулзсан ба Япон Орост хориг тавьсны дараа хоёр ч удаа уулзав.

2016 оны 12 сарын 23-нд В.В.Путин Японд айлчлах үеэрээ маргаантай нутаг дэвсгэрт эдийн засгийн үйл ажиллагаа явуулахаар тохиролцов. Энэхүү айлчлалыг дэлхийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд В.В.Путины ялалт гэж мэдээллэж байв. Айлчлалын үеэр В.В.Путин бүтэн 20 минут хоцорч ирэн Шинзо Абэг хүлээлгэж чадсан төдийгүй Абэ Оросын хатуу байр суурийн эсрэг сөрөн зогсож чадаагүй гэж үздэг.

2017 оны 4 сарын 27-нд Шинзо Абэ Орост айлчилж, энэ үеэр бүс нутгийн тулгамдсан асуудлууд, түүний дотор маргаантай газар нутгийн талаар ч ярилцав. Гэхдээ япончуудын “хойд нутаг”, оросуудын “өмнөд Курилл” гэдэг нутаг дэвсгэрийн маргааны асуудлаар зөвшилцөж чадаагүй, гэхдээ хоёр тал



тодорхой буулт хийж зарим зүйл дээр тохиролцоонд хүрч чадав. В.В.Путин тэнд амьдардаг байсан япончуудыг (ойролцоогоор 17000 хүн оросуудаас дайжин нүүсэн) өвөг дээдсээ эргэж очих нислэгийг зөвшөөрөв. Япон иргэдийг Курилл рүү аялуулах асуудлыг хялбарчилж байгаа нь хоёр орны хооронд харилцан ойлголцол, итгэлцлийн уур амьсгалыг бий болгоход тусална гэж үзэж байна гээд Шинзо Абэ энэ оны 5 дугаар сард японы бизнесийн төлөөлөгчид очиж оросын аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах талаар судалгаа хийх болсноо мэдэгдэв.

Орос Японы харилцаанд япончууд түрүүлж “буулт хийж” байгаа нь Япон улс төрийн асуудлаа шийдвэрлэхийн тулд эдийн засгийн харилцааг идэвхтэй явуулж эхэлж байна гэх санаач гарч байна. Энэхүү нөхцөл байдлыг тайлбарлахад 2015 онд Япон Ази, Номхон далайн бусад 11 улсын хамт Транс номхон далайн түншлэлийн (ТНДТ) гэрээнд гарын үсэг зурсан. Энэ нь Ази, номхон далайн бүс нутагт чөлөөт худалдаа явуулах гэрээ юм. Тус бүс нутгийн 12 орон гэрээ байгуулаад хэрэгжихийн даваан дээр 2017 онд АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трам

болсноор уг чөлөөт худалдааны гэрээнээс гарах болсноо мэдэгдэв. Өөрөөр хэлбэл АНУ өөрийн зах зээлийн орон зайд бүрэн хяналт тавьж өөрийн дүрмээр тоглох болохоо зарласан байна. Харин нөгөө талаар Хятад ч

гэсэн өөрийн зах зээлийн орон зайд ноёрхолоо бэхжүүлэх арга хэмжээ авч байна. АНУ-ыг түшдэг Японы хувьд эдийн засгийн хувьд өөрийн эрхгүй Хятад руу хандах шаардлагатай болсон ба Япон Хятадын худалдаа л гэхэд Японы АНУ-тай хийдэг худалдааг аль хэдийнэ давсан үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл Япон аюулгүй байдал, батлан хамгаалахын талаар л АНУ-ын тус бүс нутаг дахь холбоотны хэмжээ хязгаарлагдаж байна. Ийм учраас Японы хувьд ОХУ л гол түнш нь болох чиглэл тодорч ирж байна. Японы засгийн газар ОХУ-д тавьсан хоригийг үл харгалзан ОХУ-тай харилцаагаа сайжруулахыг хичээж байгаа ба энэ нь АНУ-д таалагдахгүй нь ойлгомжтой юм.

Японы гадаад бодлого нь илүү бие даасан байхыг нөхцөл байдал шаардаж, ОХУ-тай итгэлцлийг бэхжүүлэх тодорхой алхам хийж эхэлж байна. Оросын судлаачид “Япон улс нь АНУ-ын маш өндөр шахалтанд байгаа, Япон Оросын эсрэг хоригт тийм ч дуртай ороогүй. Шинзо Абэ Орос болон Их 20-ийн хоорондын харилцааг зөөлрүүлэхийг оролдож нэг ёсны зуучлагчийн үүрэг гүйцэтгэх

гэж оролдож байна” гэж дүгнэн “Оросын талаас Японтой хамтран ажиллахад бэлэн байна, гэхдээ Япон АНУ яах бол гэж харалгүй хэр бие даасан гадаад бодлого явуулж чадах вэ гэдгээс л хамаарна” гэж үзсэн байна.

Япон бүс нутагтаа Хятадтай өрсөлдөхийн тулд Оросын Алс дорнодод хөрөнгө оруулах замаар Ази руу экспорт хийх түшиц болгохыг зорьж байна. Д.Трам Транс номхон далайн түншлэлээс гарахаа мэдэгдсэний дараа Шинзо Абэ 2016 оны 11дүгээр сард Аргентин руу айлчлах үеэрээ ТРР АНУ-гүйгээр ямарч утга байхгүй болохыг мэдэгдэж байв. Гэвч энэхүү нөхцөл байдлыг үл харгалзан Японы парламентын дээд танхим ТРР гэрээг соёрхон баталсан байна. Үүнд улс орнууд уг гэрээ АНУ-гүйгээр хэрэгжиж болох эсэхийн талаар таамаг дэвшүүлэх болов. Япон улс түлшийг гаднаас импортлодог ба үүний 85 хувийг Ойрхи дорнодоос авдаг. Эдүгээ Орост энэ салбарт хөрөнгө оруулснаар нэг эх үүсвэрээс хараат байдлаа арилгахыг хичээж байна. Япон өөрийн эдийн засгийг сэргээхийн тулд хөрөнгө оруулах бүрэн боломжтой Орос руу анхаарлаа хандуулахаас өөр арга үлдээгүй. Оросоос эрчим хүчээ авснаар Япон зардлаа эрс багасгаж болно гэж оросын тал үзэж байна. Мөн Япончууд Оросын дэд бүтэц, аж үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулахыг сонирхож байна. Харин Оросын хувьд маргаантай нутаг дэвсгэрийг Японд өгөх асуудал байхгүй, харин дэд бүтэц байгуулах болон эдийн засгийн салбарт японы хөрөнгө оруулахыг дэмжиж байна.

**О.Машбат**

МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн
Бодлогын судалгааны төвийн зөвлөх профессор

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ НЬ:

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа системийн цэгцийг хадгалах явдал хамгийн чухал бөгөөд хуульч хүн бүрийн анхаарах ёстой асуудал юм. Системийн цэгц буюу system integrity гэдгийг маш энгийнээр тодорхойлбол гадаад, дотоод аливаа өөрчлөлт, тогорт саармагжиж, гацахгүйгээр функцээ гүйцэтгэсээр байх системийн байдлыг хэлэх бөгөөд аливаа хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт тухайн хуулийнхаа цэгцийг хадгалж, харин ч бэхжүүлж байх ёстой. Манай Үндсэн хууль системийн хувьд цэгц: зарим элементийн функцийг тодруулж, тохируулга хийх ёстой болохоос шинэ шинэ элемент нэмж засна гэвэл системийн цэгцийг алдагдуулах нь дамжиггүй юм.

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байгаа таван асуудлаас хоёр нь, тухайлбал, Төрийн албаны зөвлөл, Төрийн хяналтын байгууллагыг Үндсэн хуулийн институуц болгох асуудалд нарийн зохицуулалт хийхгүй бол системийн цэгцийг алдагдуулж магадгүй эрсдэлтэй байна.

СИСТЕМИЙН ЦЭГЦИЙГ АЛДАГДУУЛАХ АЮУЛ

Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл харилцан тэнцэлтэй, нэгдмэл байвал жигд ажилладгийг Ази, Европын ардчилсан олон орны жишээ харуулж байна. Харин эрх мэдлүүдийг салаалбал үр дүнтэй ажиллаж чаддаггүй болохыг гүйцэтгэх эрх мэдлийг салаалж, хариуцлагыг эзгүйдүүлсэн 25 жилийн түүх илэрхий харуулна.

Төрийн албаны зөвлөл, Төрийн хяналтын байгууллагыг байгуулснаар наад зах нь гурван төрлийн доголдол үндсэн хуулийн системд гарна. Эдгээрийг тус бүрт нь авч үзье.

- Гүйцэтгэх эрх мэдэл салаалах
- Шүүх эрх мэдлийг салаалах
- Ард түмний мандат үнэгүйдэх

Аливаа байгууллагад оршин байх институуцийн амбиц гэдэг ойлголт энэ асуудлыг тайлбарлахад гол үүрэгтэй. Институуцийн амбицийг хоёр янзаар тайлбарладаг. Хувь этгээд амбицаа хэрэгжүүлэхэд институуц боломж олгодог гэж зарим нь үздэг бол хэн удирдлагад нь байхаас үл хамааран аливаа

бүлэг, байгууллага, тогтолцоо, өөрөөр хэлбэл институуц өөрөө нөлөөгөө тэлэх хандлагатай байдаг гэж өөр нэг хэсэг нь үздэг. Аль нь боловч тийн тэлэхийг нь хязгаарласан өөр нэг институуцийн тогтмол хяналтын үр дүнд л институуц үндсэн үүргээ гүйцэтгэн хязгаартаа оршино, эс бөгөөс тухайн институуц өөрөө ажиллаж чадахгүй болтлоо томорсоор задарна.

Үүний жишээ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн институуцийн тэлэлт юм. Манай ерөнхийлөгчийн институуц эхний үедээ төдийлөн хүчтэй байгаагүй, систем дотроо гүйцэтгэх үндсэн үүргээ гүйцэтгэж байлаа /1993-1997/. Үүний дараа Ерөнхий сайдыг томилох асуудлаар УИХ-тай зөвшилцөх бус, харин ч тулган шаардах шинжтэй үйлдэл гаргаж байв. 1998 онд Ардчилсан холбоо эвслийн нэр бүхий хэдэн гишүүнийг л Ерөнхий сайд болгох асуудлаар зөвшилцөж болно, өөрөөр зөвшилцөх боломжгүй хэмээн хатуу илэрхийлж байлаа. Үүний улмаас УИХ-ын олонх, цөөнхийн

бүлэг нийлж, энэ эрх хэмжээг нь хязгаарлах зорилгоор Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд хожим нь тэдгээр нэмэлт өөрчлөлтийг “дордохын долоо” хэмээн хочлох болсон билээ.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн оролцоо, Ерөнхийлөгчийн зөвлөхүүдийн эрх мэдэл гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаа, томилт руу шууд оролцох хүртлээ тэлэх болсон явдал өнөөдөр Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад хүргэж байгаа гол үндэслэлүүдийн нэг бөгөөд институтийн амбиц хэн ерөнхийлөгч байснаас үл хамааран эрх мэдлээ тэлэхэд чиглэж байдгийг харуулж байна.

Гүйцэтгэх эрх мэдлийг салаалах нь

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гол зорилго бол ялсан намын амлалтыг биелүүлэх үүргийг Ерөнхий сайд биеэрээ хариуцдаг болгоход оршино. Өнөөдрийн байдлаар гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхий сайд, Ерөнхийлөгч хоёрын дунд салаалсан учир засгийн газар нэг тушаалаар шатлан захирагдаж жигд ажиллах боломжгүй байна.

Гүйцэтгэх эрх мэдэл оролцох Ерөнхийлөгчийн оролцоог хязгаарлах, УИХ-д улстөрийн хариуцлага тооцдог болгох замаар Ерөнхий сайдын дор гүйцэтгэх эрх мэдлийг төвлөрүүлэн зангидах бодлогын улмаас энэ нэмэлт, өөрчлөлтийг хийх гэж буй.

Гэтэл Төрийн албаны зөвлөлийг Үндсэн хуулийн байгууллага болгосноор гүйцэтгэх эрх мэдлийг дахин

салаалахад хүргэнэ. Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хадгалж, улстөрчдийн зоргоор төрийн албан хаагчийг сольдог явдлыг эцэслэхийг энэ нэмэлт, өөрчлөлт оролдож байна. Гэвч, төрийн албаны тогтвортой байдлыг хангахын тулд Үндсэн хуулийн институтийг шинээр байгуулбал ийм үр дүнд хүрнэ гэсэн баттай, ноттой судалгаа огт үгүй байна. Ийм системийг авсан орнуудын төрийн албаны тогтолцоо тогтвортой байдаг гэсэн жишээ мэр сэр буй боловч аваагүй атлаа тогтвортой байгаа жишээ бүр ч олон бий.

Үндсэн хуулийн хүрээнд төрийн албаны тогтвортой байдлын тухай гол асуудлыг арай өөрөөр тавьдаг – нэг талаас, төрийг тогтвортой, үр дүнтэй ажилладаг байлгахын тулд түшмэдийн мэргэшсэн институтийг /энд байгууллага гэсэн утгаар хэлээгүй, тогтолцоо гэдэг утгаар хэрэглэж байгааг анхаарнау/ тогтвортой байлгах: нөгөө талаас, төрийг бүхэлд нь угсаа залгасан мэргэжлийн түшмэдийн гарт алдахгүйн тулд төрийн эрх мэдлийг сонгуулиар ард түмнээсээ итгэл хүлээсэн төлөөлөгчдийн гарт байлгах, - энэ хоёрын тэнцвэрийг хэрхэн хадгалах вэ гэдэгт оршино. Энэ хоёрын аль нь илүү чухал вэ гэвэл “төрийн эрх ард түмнээс сурвалжтай”-ийн хувьд ардчиллыг хадгалахын тулд ардын төлөөлөгчдийн гарт эрх мэдэл байх нь зүйтэй гэдэг нь жин дарна.

ТАЗ-ийг Үндсэн хуулийн байгууллага болговол төрийн албан хаагчийн баталгаа сайжирч болох авч “төрийн эрх мэдэл ард түмнээс сурвалжтай” гэдэг зарчим бүрхэг болж, улмаар ардын төлөөлөгчийн үүрэг

хумигдаж, ардчилал хумигдах аюултай.

Ерөнхий сайдын шийдвэрийг эсэргүүцдэг, төрийн албан дахь явцуу бүлэглэл Ерөнхийлөгчийг тойрон хүрээлж, түүний эрх мэдлийг тэлсэнтэй адил тэдгээр бүлэглэл Төрийн албаны зөвлөлийг тойрон хүрээлж, баттай цайз босгож эхэлнэ. Улмаар өнөөдөр байгаа төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй мэргэжлийн явцуу жижиг бүлэглэл яам, агентлагт дархлагдсан эзэн болно. Тэд эрх ямбаа хадгалж үлдэхийн тулд салбарын сайдынхаа бодлогыг эсэргүүцэж Засгийн газрын шийдвэрийг гүйцэтгэхгүй, түүнийх нь төлөө хариуцлага тооцоход бэрх болох магадлалтай.

Шүүх эрх мэдлийг салаалах нь

Аливаа маргааныг шүүхээр шийдэх ёстой гэсэн Үндсэн хуулийн зарчимтай Төрийн хяналтын байгууллага байгуулах явдал харшилж байна. Ийм институтийг байгуулбал яваандаа шүүхийн хяналтыг салаалж, шүүх эрх мэдлийг хүчгүй болгох аюултай.

Эрх зөрчигдвөл зарга үүсгэж, шүүхээр шийдүүлдэг явдлыг өрнийн соёлын тусгал хэмээн тайлбарлаж болох ч дорнын соёлын тусгал болгон санал болгож байгаа системийг авч үзвэл туйлын сонирхолтой. Эзэн хаанаас томилсон бүрэн эрхт түшмэлүүд орон нутгаар шалган явж, хүн зоны аж төрөл, гомдол саналыг бүртгэн засаг хэрхэн хэрэгжиж байгааг эзэн хаанд эргэж илтгэдэг байжээ. Гэвч

энэ нь бодит байдал дээр муж, хошууны засаг ноёдын эсрэг хов цуглуулах систем бий болгосон бөгөөд ямар ховыг хэний эсрэг хэрэглэх нь үнэндээ эзэн хааны үзэмжийн асуудал болж байжээ. Энэ систем Хятадын олон муж, хошууны жижиг ноёдыг атгаж байх гол суваг, ямагт чухал системд тооцогдож байв.

Тайвань буюу Дундад иргэн улс гэгчийн Үндсэн хуулийг батлах үед Манж дайчин гүрэн нурж, хятадын муж бүрийг нэг нэг цэргийн эрхтэн захирч, төвлөрсөн засаглал үнэндээ алга болчихсон шахуу байсан бөгөөд тэдгээрийг хятадын уламжлалт аргаар төв засгийн газрын хяналтад авахын тулд энэ институтыг хадгалахын тулд Байцаах юань буюу Төрийн хяналтын байгууллагыг байгуулсан аж. Үүнийг Күнзийн үндсэн хуульт ёс хэмээн нэрийдэх нь ч бий бөгөөд күнзийн ёсыг эрт дээр үеэс шүтсэн Солонгос ч дэлхийн хоёрдугаар дайны дараа анхныхаа үндсэн хуульд бас тусгасан гэдэг.

Тайвань буюу Дундад иргэн улс гэгчийн төрийн байгуулалд Байцаах юань буюу Төрийн хяналтын байгууллагын эрх мэдэл асар их – манай үндсэн хуулийн нэмэлтэд энэ байгууллагад ямар эрх мэдэл өгөх нь тодорхойгүй байна. Төслийг үзвэл, БНМАУ-ын үед байсан прокурорын ерөнхий хяналтын эрх мэдэл, Ардын хянан шалгах хорооны эрх мэдэл дээр өнөөгийн улсын ерөнхий аудитор, Хүний эрхийн комиссын бүх эрх мэдлийг энэ байгууллагад өгч магадгүй юм.

Авлигатай тэмцэх газар улстөрийн захиалгаар ажилладаг Гестапо болж тэлсэн сүүлийн 10 жилийн түүхийг үзвэл Үндсэн хуулийн институтын түвшинд ийм байгууллагатай болох вий гэсэн айдас зүй ёсоор төрж байна.

Ард түмний мандат үнэгүйдэх нь

“Засгийн эрх ард түмний гарт” гэх зарчмыг бодитоор нь хэрэгжүүлэхийн тулд УИХ-ын эрх мэдлийг нэмэгдүүлсэн – үүнээс болоод төрийн эрх мэдэл хуваарилах зарчим алдагдаж 25 жил ужгирсаар өнөөгийн хямрал үүссэн.

УИХ-ын эрх мэдлийг хумьж “хууль тогтоох байгууллага”-ын хэмжээнд аваачих зорилгоор Үндсэн хуульд хийх гэж байгаа энэ нэмэлт, өөрчлөлт одоо ард түмнийхээ мандатыг үнэгүйдүүлэх чиглэл рүү хазайж байх шиг. Гүйцэтгэх эрх мэдлийг улстөржилтөөс салгахын тулд Ерөнхий сайд ажлаа хийхэд нь УИХ-аас саад болдгийг болиулах, гэхдээ УИХ-ын хяналтынх нь чиг үүргийг нэмэгдүүлэх ёстой юм.

Гэтэл Төрийн албаны зөвлөл, Төрийн хяналтын байгууллага гэх мэт институтыг байгуулж “төрийн албаны тогтвортой байдал”, “үйл ажиллагааны болон хариуцлагын хяналт”-ыг УИХ-ын эрх мэдлээс салгах гэж оролдох нь үнэндээ УИХ-ыг хүчгүйдүүлэх бодлого мэт харагдаж байна.

Дүгнэлт

УИХ, Засгийн газар, Шүүх гэсэн гурван салаанд төрийн эрх мэдлийг хуваарилах Үндсэн хуулийн уг санааг таван салаанд хуваахаар санал оруулж буй явдлыг “нэмэлт, өөрчлөлт” гэж биш, харин “төрийн эргэлт” гэж нэрлэхээр байна. Нөгөө талаар, энэ “төрийн эргэлт” зөв байсан ч, эдгээр өөрчлөлтийг хийсэн ч гэсэн, эдгээр нь үнэхээр сайхан санаа байсан ч гэсэн үр дүнгээ өгөхгүй гэдгийг мэргэ төлөг тавихгүйгээр өнөөдөр шууд хэлж болохоор байна.

Системийн элемент бүр хоорондоо хэрхэн харилцах нь ойлгомжтой, функц нь тодорхой байх ёстой. УИХ, Засгийн газар, шүүх гурван эрх мэдэл – элементийнхээ хоорондын харилцааг хяналттай, тэнцэлтэй хуваарилж чадахгүй байж, таван элементийн хооронд бүрэн хяналттай, тэнцэлтэй хуваарилж чадна гэдэгт итгэхэд бэрх. Хэлэлцүүлж байгаа төсөлд Төрийн албаны зөвлөл, Төрийн хяналтын байгууллага хоёр нь УИХ, Засгийн газар, шүүх гуравтайгаа хэрхэн харилцахыг одоогоор огт заагаагүй байгаа нь эргэлзээг улам гүнзгийрүүлж байна.

Төрийн албаны зөвлөл, Төрийн хяналтын байгууллага гэсэн хоёр байгууллагыг шинээр байгуулах тухай Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн санал нь Монгол Улсын Үндсэн хуулийн системийн цэгцийг алдагдуулах эрсдэлтэй гэж дүгнэх нь зүйтэй байна.

ТООН МЭДЭЭ

ЕРӨНХИЙ САЙД Ж.ЭРДЭНЭБАТЫН БНХАУ-Д ХИЙСЭН АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛЫН ТУХАЙ



АЛБАНЫ БОЛОН АЖИЛ ХЭРГИЙН ХОЁР ТАЛЫН УУЛЗАЛТ:



- Тухайлбар**
- "Хөгжлийн зам" болон "Бус ба Зам" санаачилгыг уялдуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг
 - Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах тухай Монгол Улсын Эрчим хүчний яам, БНХАУ-ын "Чайна Датан" групп хамтран судалгаа хийх, хамтарч ажиллах тухай санамж бичиг
 - Махан бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх үеийн хорио цээр, хяналтын тухай Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон БНХАУ-ын Чанарын Хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг
 - Замын-Үүд-Эрээн боомтын хамтын ажиллагааг өргөжүүлэх дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх
 - БНХАУ-ын Засгийн газрын 500 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн хүрээнд "Туул гол дээгүүрх Баянзүрхийн 321 у/м болон Сонголгогийн 289.4 у/м төмөр бетон гүүр шинээр барих" төслийн тусгайлан зээлийн хэлэлцээр
 - Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг барих" төслийн хоёр сургууль, нэг цэцэрлэг барих тухай солилцох захидал

АЙЛЧЛАЛЫН ЗАРИМ ОНЦГОЙ ШИЙДВЭР, ТОХИРОО


- Тухайлбар**
- Говийн бүсийн дэд бүтэц, эрчим хүчний том төслүүдээ хөдөлгөх, эрчимжүүлэх
 - Хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, Гашуунсухайт боомтын ажиллах цагийн хуваарийг 12 цаг байсныг 16 цаг болгож сунгах
 - Улаанбаатарын гэр хорооллыг орон сууцжуулах
 - БНХАУ-аас хоёр тэрбум юанийн буцалтгүй тусламж үзүүлэх
 - БНХАУ-ын Ардын Банк Монголбанк хооронд байгуулсан своп хэлэлцээрийн хугацааг сунгах



Эх сурвалж: itoim.mn

НОМЫН ЕРТӨНЦӨӨР


АМЕРИКИЙН КОНСУЛ СОКОБИН МОНГОЛЫН ТУХАЙ 1921-1924 /Баримтын эмхэтгэл/



Түүхийн ухааны доктор, Элчин сайд Р.Болдын ээлжит ном хэвлэлээс гараад нэн удаагүй байгаа бөгөөд манай судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж байна. Тэрбээр энэ удаа 20 дугаар зууны эхээр Хаалганд сууж байсан Америкийн консул С.Сокобины тэр үеийн Монголын талаар Вашингтонд илгээж байсан өргөн хүрээтэй мэдээ материалыг англи хэлнээс орчуулан эмхэтгэжээ.

Самуэл Сокобин 1921 оны 8-9 дүгээр сард анх удаа, түүнээс хойш хэд хэдэн удаа Ар Монголд зорчиж, тэр үеийн ээдрээтэй нөхцөл байдал, холбогдох гүрнүүдийн байр суурь, үйл ажиллагааг судлан, өөрийн санаа бодол, үнэлэлт дүгнэлтээ удирдлагадаа илтгэж байсан байдаг. С.Сокобин нь АНУ-ын дипломат албанд он удаан жил хүчин зүтгэхдээ “юм юмыг” үзсэн, америкийн урдаа барьдаг ази, хятад судлаач байсан юм. Түүний бичиж үлдээсэн баримт материалууд нь Автономит Монгол болон ардын хувьсгалын эхний жилүүдийн бодит түүх, тухайлбал АНУ-ын хандлага, байр суурийг цаашид гүнзгийрүүлэн судлахад үнэтэй хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй.

Х.Бэхбат



Монгол улс, Улаанбаатар хот, СБД,
МУИС-ОУХНУС V байр 308 тоот

✉ thinktanks99@gmail.com

☎ 976 99070579

☎ 976-11354610